



НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГА Ж.ГАНХУЯГ ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2014.12.12 № 03/10571

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Хуулийн хэрэгжилтийг хангуулах  
тухай

Авлигатай тэмцэх газрын даргын баталсан удирдамжийн дагуу Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх болон Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтэс, Судалгаа шинжилгээний албанаас томилогдсон ажлын хэсэг 2014 оны 09 дүгээр сарын 24-нөөс 2014 оны 10 дугаар сарын 1-ний өдрүүдэд Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтэс байгууллагуудын авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцлаа.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн байдалтай танилцахад илэрсэн зөрчил, дутагдалд дараах арга хэмжээг авах шаардлагатай байна. Үүнд:

1/ Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах;

2/ “Үнэлгээний хороо” байгуулсан тушаал гаргахдаа орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээг гүйцэтгэх үнийн дүнг тодорхой тусгахаас зайлсхийх;

3/ эрх зүйн акт гаргах үндэслэлээ холбогдох хуулийн заалтад нийцүүлэх;

4/ давхар ажил эрхлэлттэй холбоотой болон хамаарал бүхий этгээдийн ажил эрхлэлтийн нэгдсэн судалгааг дүүргийн хэмжээнд гаргаж, нээлттэй болгох;

5/ төсвийн хөрөнгийг үр дүнтэй, зориулалтын дагуу зарцуулдаг байх, нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;

6/ дүүргийн удирдлагууд болон ажилтнууд гадаадад томилолтоор ажилласан талаарх санхүүгийн тайлан, айлчлалын үр дүнгийн талаар нийтэд мэдээлдэг болох зэрэг болно.

Иймд Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг чанд мөрдөж, дээр дурдсан зөрчил дутагдлыг дахин гаргахгүйгээр ажиллах талаар дүүргийн Засаг даргын Тамгын газар, эрхлэх асуудлын хүрээний байгууллага, албан тушаалтнуудыг хамруулсан тодорхой арга хэмжээг зохион байгуулж дүнг 2015 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

З.БААСАННЯМ

C:\DOCUMENTS\ALBANBICHIG\A4

021766